



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 04 сарын 21 өдөр

№ 05

Улаанбаатар хот

Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь хэсэг, компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 2027 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаатайгаар сонгосугай. Үүнд:

Хяналтын зөвлөлийн гишүүн: Д.Ганзориг
Хяналтын зөвлөлийн гишүүн: Ж.Ариунгэрэл
Хяналтын зөвлөлийн гишүүн: С.Хулан

2. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүний урамшууллын хэмжээг хуралд оролцсон сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор сонгогдсон Хяналтын зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болгосугай.
4. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүний урамшууллыг тэдгээрийн хуралд оролцсон ирцийг үндэслэн тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналтын зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР